



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 6/115.

Хэрлэн сум

Л.Дугарыг албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жолооч Ламзавын Дугар нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажил хүлээлцүүлэх

комиссын дарга: Н.Баярсайхан

Аж ахуйн тасгийн дарга

Гишүүд:

С.Сарангоо

Хөдөлмөрийн аюулгүй байдал,
зохион байгуулалт хариуцсан
ажилтан


Т.Баяртуяа

Нярав

3. Л.Дугар нь өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаатай холбогдуулан 36 сарын үндсэн цалингийн дундажтай тэнцэх хэмжээний 1 удаагийн буцалтгүй тусламжийг олгосугай.

4. Л.Дугарын ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Баярсайхан)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА